

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/34/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272682 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amajargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр туйцэтгэсэн: "Голден пейж Аудит" ХХК
захирал: С.Ожунгарал

Утас: 70117179 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.creaudit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цэвэр шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/96.

танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Б.ТҮВШИН-ТАМИР ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын төсвийн санхүүжилтээр 1,175.75 метр барилгажсан талбайтай 2,286.2 мянган төгрөгийн өртөг бүхий 15 ортой 2 давхар эрүүл мэндийн төвийн барилгыг Барилга менежмент ХХК-тай гэрээлэн 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ашиглалтанд хүлээн авч эмнэлгийн үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийн хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоосонтой холбоотой мөнгөн хөрөнгийн данс 167,220.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

019000123

Аудитын гол асуудал

Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эргэлтийн эмийн сангаар дамжуулан эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг эрхлэн явуулдаг, эм борлуулсны орлого 55,704.9 мянган төгрөг цахим баримтад илүү шивэгдсэн байна.

Эргэлтийн эмийн сан нь байрны түрээсийн төлбөр, түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууныг зарцуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Нийгмийн эрүүл мэндийн ажлын хүрээнд 3 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж эрүүл мэндийн газраар 98,8 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>202,633,861.64</u>	<u>238,365,634.63</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	96,574,589.45	167,220,533.68
312	Банканд байгаа бэлэн мөнгө	96,574,589.45	167,220,533.68
3121	Төгрөг	96,574,589.45	167,220,533.68
31211	Төрийн сангийн харилцах	96,574,589.45	167,220,533.68
33	АВЛАГА	00.00	1,068,614.00
335	Бусад авлага	00.00	1,068,614.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,068,614.00
35	БАРАА МАТЕРИАЛ	106,059,272.19	70,076,486.85
351	Түүхий эд материал	71,363,829.83	47,331,932.33
35110	Тусгай зориулалттай материал	7,006,793.90	22,196,418.30
35130	Эм боох материал	64,357,035.93	25,135,514.03
354	Хангамжийн материал	34,695,442.36	22,744,554.52
35410	Бичиг хэргийн материал	75,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	4,091,300.00	868,860.00
35430	Сэлбэг хэрэгсэл	650,000.00	280,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,837,588.00	00.00
35460	Хүнсний материал	2,558,285.00	584,470.00
35470	Бусад хангамжийн материал	25,683,269.36	21,011,224.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>596,950,081.74</u>	<u>2,987,483,217.42</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	596,950,081.74	2,987,483,217.42
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	592,588,231.74	2,981,225,317.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	333,663,674.00	2,467,286,530.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-51,161,155.78	-85,851,695.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	150,452,325.00	145,832,325.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-52,058,081.26	-64,177,121.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	273,306,290.01	441,087,472.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-89,485,440.75	-101,904,191.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,703,712.92	56,973,842.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,963,092.40	-3,717,053.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	125,565,210.00
39217	Ном	130,000.00	130,000.00
393	Биет бус хөрөнгө	4,361,850.00	6,257,900.00
39301	Программ хангамж	50,000.00	50,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,311,850.00	6,311,850.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-103,950.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>799,583,943.38</u>	<u>3,225,848,851.95</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>799,583,943.38</u>	<u>3,225,848,851.95</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	799,583,943.38	3,225,848,851.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	291,712,432.11	291,712,432.11
51101	Өмч: - төрийн	291,712,432.11	291,712,432.11

512	Хуримтлагдсан үр дүн	286,802,984.55	2,713,067,893.12
51210	Өмнөх үеийн үр дүн	286,802,984.55	286,802,984.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,426,264,908.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	221,068,526.72	221,068,526.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	799,683,943.38	3,226,848,851.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	883,743,626.01	3,247,311,146.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	167,114,476.01	2,490,773,841.22
120	Нийтлэг татварын бус орлого	167,114,476.01	2,490,773,841.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	162,655,002.01	2,490,773,841.22
120009	Бусад орлого	4,459,474.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	716,629,150.00	756,537,304.51
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,773,700.00	66,402,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,773,700.00	66,402,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	694,605,450.00	689,135,204.51
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	694,605,450.00	689,135,204.51
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	688,714,634.29	799,585,599.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	688,714,634.29	799,585,599.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	688,425,814.29	764,989,984.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	361,654,052.47	387,779,836.55
210101	Үндсэн цалин	201,543,172.47	239,396,663.14
210102	Нэмэгдэл	135,895,287.00	118,152,896.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,353,000.00	4,723,996.05
210104	Урамшуулал	19,862,593.00	25,506,280.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,020,865.36	48,680,271.73
210201	Тэтгэврийн даатгал	30,720,206.64	34,131,811.96
210202	Тэтгэмжийн даатгал	3,376,759.47	3,998,677.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,590,447.55	3,097,741.75
210204	Ажилгүйдлийн даатгал	591,248.70	677,457.49
210205	Эрүүл мэндийн даатгал	5,742,203.00	6,774,582.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,053,590.00	32,386,332.74
210301	Гэрэл, цахилгаан	5,071,800.00	7,892,884.34
210302	Түлш, халаалт	14,981,790.00	24,493,448.40
2104	Хангамж, бараа материалын зардал	39,515,910.00	36,581,188.00
210401	Бичиг хэрэг	3,205,350.00	2,395,800.00
210402	Тээвэр, шатахуун	31,286,660.00	29,203,388.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	955,900.00	1,141,800.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,068,000.00	3,840,200.00
2105	Нормативд зардал	135,034,612.80	121,380,229.77
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,521,547.80	103,967,914.77
210502	Хоол, хүнс	13,908,065.00	16,372,315.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	605,000.00	1,040,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,818,000.00	10,124,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	126,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	95,000.00	00.00
210604	Урсгал засвар	13,597,000.00	10,124,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,310,000.00	1,792,000.00
210702	Дотоод албан томилолт	1,310,000.00	1,792,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	1,637,034.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	136,125.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	233,190.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	117,852.00
210807	Газрын төлбөр	00.00	400,867.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	425,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,018,783.66	124,628,591.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,739,038.00	16,195,840.00
210903	үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,279,745.66	108,432,751.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	288,820.00	34,595,615.26
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	288,820.00	34,595,615.26
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	288,820.00	34,595,615.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	195,028,991.72	2,447,725,545.86
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	21,460,637.29
225001	үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	21,460,637.29
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-21,460,637.29
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	195,028,991.72	2,426,264,908.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	796,215,624.00	755,468,690.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,459,474.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,459,474.00	00.00
120009	Бусад орлого	4,459,474.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	791,756,150.00	755,468,690.51
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,773,700.00	66,402,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,773,700.00	66,402,100.00
1330	Төсвийн захирагчдаас	769,732,450.00	688,066,590.51
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	769,732,450.00	688,066,590.51
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	708,309,318.12	684,822,746.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	708,309,318.12	684,822,746.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	708,020,498.12	650,227,131.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	361,405,051.26	387,779,836.55
210101	Үндсэн цалин	201,084,171.26	233,650,492.14
210102	Нэмэгдэл	136,105,287.00	123,899,067.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,353,000.00	4,723,996.05
210104	Урамшуулал	19,862,593.00	25,506,280.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,020,865.36	48,680,271.73
210201	Тэтгэврийн даатгал	30,720,206.64	34,131,811.96
210202	Тэтгэмжийн даатгал	3,376,759.47	3,998,677.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,590,447.55	3,097,741.75
210204	Ажилгүйдлийн даатгал	591,248.70	677,457.49
210205	Эрүүл мэндийн даатгал	5,742,203.00	6,774,582.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,984,880.00	31,681,984.74
210301	Гэрэл, цахилгаан	5,071,800.00	7,892,884.34
210302	Түлш, халаалт	14,913,080.00	23,789,100.40
2104	Хангамж, бараа материалын зардал	40,269,150.00	36,067,600.00
210401	Бичиг хэрэг	3,475,350.00	2,395,800.00
210402	Тээвэр, шатахуун	32,219,900.00	28,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	955,900.00	1,141,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,818,000.00	3,780,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	450,000.00
2105	Нормативд зардал	160,472,073.50	61,913,141.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	139,507,884.00	46,474,641.00
210502	Хоол, хүнс	15,964,189.50	14,398,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	1,040,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,283,950.00	54,764,200.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	24,793,300.00	18,259,700.00
210602	Тавилга	12,100,000.00	26,380,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,890,650.00	00.00
210604	Урсгал засвар	22,500,000.00	10,124,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,310,000.00	1,792,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,310,000.00	1,792,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	1,607,182.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	136,125.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	233,190.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	88,000.00
210807	Газрын төлбөр	00.00	400,867.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	425,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,274,528.00	25,940,915.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,274,528.00	25,940,915.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	288,820.00	34,595,615.26
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	288,820.00	34,595,615.26
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	288,820.00	34,595,615.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	87,906,305.88	70,645,944.23
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	87,906,305.88	70,645,944.23
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,668,283.57	96,574,589.45
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	96,574,589.45	167,220,533.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	287,712,432.11	195,875,816.57	-114,933,284.68	368,654,964.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	287,712,432.11	195,875,816.57	-114,933,284.68	368,654,964.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-20,617,002.93	-20,617,002.93
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	291,712,432.11	221,068,526.72	286,802,984.55	799,583,943.38
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	291,712,432.11	221,068,526.72	286,802,984.55	799,583,943.38
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	291,712,432.11	221,068,526.72	286,802,984.55	799,583,943.38
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,426,264,908.57	2,426,264,908.57
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	291,712,432.11	221,068,526.72	2,713,067,893.12	3,225,848,851.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	897,074,700.00	618,420,646.28	278,654,053.72	68.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	897,074,700.00	618,420,646.28	278,654,053.72	68.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	887,074,700.00	618,420,646.28	268,654,053.72	69.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	611,382,200.00	387,779,836.55	223,602,363.45	63.4
210101	Үндсэн цалин	256,843,200.00	233,650,492.14	23,192,707.86	91.0
210102	Нэмэгдэл	267,210,200.00	123,899,067.40	143,311,132.60	46.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,468,400.00	4,723,996.05	744,403.95	86.4
210104	Урамшуулал	81,860,400.00	25,506,280.96	56,354,119.04	31.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,243,400.00	48,680,271.73	25,563,128.27	65.6
210201	Тэтгэврийн даатгал	50,485,800.00	34,131,811.96	16,353,988.04	67.6
210202	Тэтгэмжийн даатгал	5,938,800.00	3,998,677.60	1,940,122.40	67.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,751,700.00	3,097,741.75	1,653,958.25	65.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,188,000.00	677,457.49	510,542.51	57.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,879,100.00	6,774,582.93	5,104,517.07	57.0
2104	Хангамж, бараа материалын зардал	49,940,700.00	36,067,600.00	13,873,100.00	72.2
210401	Бичиг хэрэг	2,395,800.00	2,395,800.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	41,064,900.00	28,300,000.00	12,764,900.00	68.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,250,000.00	1,141,800.00	1,108,200.00	50.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,780,000.00	3,780,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	450,000.00	450,000.00	-	100.0
2105	Нормативд зардал	63,901,400.00	61,913,141.00	1,988,259.00	96.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн харагсал	46,474,900.00	46,474,641.00	259.00	100.0
210502	Хоол, хүнс	16,226,500.00	14,398,500.00	1,828,000.00	88.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	1,040,000.00	160,000.00	86.7

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,139,700.00	54,639,700.00	(3,500,000.00)	106.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,759,700.00	18,259,700.00	1,500,000.00	92.4
210602	Тавилга	20,380,000.00	26,380,000.00	(6,000,000.00)	129.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	-	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,564,000.00	1,792,000.00	1,772,000.00	50.3
210702	Дотоод албан томилолт	3,564,000.00	1,792,000.00	1,772,000.00	50.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,884,000.00	1,607,182.00	276,818.00	85.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	136,125.00	63,875.00	68.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	233,190.00	16,810.00	93.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	88,000.00	12,000.00	88.0
210807	Газрын төлбөр	410,000.00	400,867.00	9,133.00	97.8
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	600,000.00	425,000.00	175,000.00	70.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,019,300.00	25,940,915.00	5,078,385.00	83.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,019,300.00	25,940,915.00	5,078,385.00	83.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,000,000.00	-	10,000,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,000,000.00	-	10,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шалгал урамшуулал	10,000,000.00	-	10,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	962,996,700.00	689,066,590.51	273,930,109.49	71.6
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	866,422,100.00	688,066,590.51	178,355,509.49	79.4
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	866,422,100.00	688,066,590.51	178,355,509.49	79.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	96,574,600.00	-	96,574,600.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	96,574,600.00	-	96,574,600.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	96,574,589.45	(96,574,589.45)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	167,220,533.68	(167,220,533.68)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26	21	5.00	80.8
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15	13	2.00	86.7
620003	Үйлчлэх ажилтан	10	7	3.00	70.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилгоо "Үйлчлүүлэгчдэд гол анхаарлаа хандуулан тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, цаг алдалгүй эмчлэн эрүүлжүүлэхээс гадна нийгмийн эрүүл мэндийн цогц үйлчилгээг орчин үеийн арга барилаар явуулж урьдчилан сэргийлэх дадал хэвшлийг эзэмшүүлнэ" гэж тодорхойлсон.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д "Хот суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ" үзүүлдэг Эрүүл мэндийн сайдын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн чиг үүргийг эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх, сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлсон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон байна.

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Эрүүл мэндийн тухай хууль
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- ✓ Зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Эм, эмнэлгийн хэрэглэлийн тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,426,264.9 мянган төгрөгөөр буюу 247,8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	96,574.59	167,220.53	70,645.94
Авлага		1,068.61	1,068.61
Урьдчилгаа			-
Бараа материал	106,059.27	70,076.49	(35,982.79)
Үндсэн хөрөнгө	596,950.08	2,987,483.22	2,390,533.14
Нийт хөрөнгө	799,583.94	3,225,848.85	2,426,264.91
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	291,712.43	291,712.43	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	799,583.94	3,225,848.85	2,426,264.91

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Авлагын дансны үлдэгдэл 1,068.6 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн нийгмийн даатгалын санхүүжилтээс авлагатай гарч тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материал 70,076.4 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн тушаалаар тусгай зориулалттай материал, бусад хангамжийн материал, сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материал зэрэг эргэлтийн хөрөнгийг акталж устгасан, эм боох материал, түлш шатах тослох материал зэрэг үлдэгдэлтэй байсан хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,390,533.1 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15 ортой эмнэлгийн шинэ барилга 11 дүгээр сарын 07-ны өдөр

ашиглалтад орсон. Эрүүл мэндийн яамнаас 101,200.0 төгрөгийн үнэ хүчил төрөгчийн генератор хандив тусламжаар өгсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 752,766.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 71,411.1 мянган төгрөг, нийт зарлагыг 801,812.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 5,009.0 мянган төгрөгөөр бууруулж, 66,402.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2023 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл эмнэлгийн шинэ байр ашиглалтад орохтой холбоотой тооцоол буруу хийснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 144,308.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 144,308.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн орлогоос бүрдүүлэхээр байна. 2023 оны 7 сард Эрүүл мэндийн даатгалын сангийн нэг иргэний санхүүжилт нь нэмэгдсэнтэй холбоотой нэмэгдсэн.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 688,066.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээр 66,402.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 618,420.6 мянган төгрөг буюу 68,9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 278,654.0 мянган төгрөг, тогтмол зардлыг 34,595.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Үндсэн үйл ажиллагааны зардлыг 278,654.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан харагдаж байгаа мэт боловч Эрүүл мэндийн даатгалын сангаас авах гүйцэтгэлийн санхүүжилтийг 91,988.0 мянган төгрөгөөр дутуу авсантай холбоотой зардал хэмнэгдсэн мэт харагдаж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80302- нэг иргэнд ногдох нормативаар	613,671.50	593,225.90	20,445.60	96.7
2	81603- үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	186,828.60	94,840.60	91,988.00	50.8
3	83603-нэмэлт дээд шатны төсвөөс хувиарласан	96,574.50	96,574.50	0.00	100.0
4	80111- байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	66,402.10	66,402.10	0.00	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагаанд 9 ажил үйлчилгээний 212,662.2 мянган төгрөгийн төлөвлөгөө батлуулснаас 124,517.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. Хэмнэгдсэн шалтгаан нь шинэ эмнэлгийн барилга ашиглалтад орох хугацаа хойшлогдон халаалт, гэрэл цахилгааны төлбөр хэмнэгдсэн, эм бэлдмэл, түлш шатах тослох материал зэрэг нь хэмнэлттэй ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Я.Оюун, Шинжээч Ц.Цацрал Х.Ариунжаргал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, үе шатны хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 12/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 549,525.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 8,242.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,182.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг хэмнэн ажилласан. Байр ашиглахтай холбоотой тогтмол зардлаас гэрэл цахилгааны төлбөр 158.7 мянган төгрөгөөр хэтэрсэн нь 2023 оны 11 дүгээр сард шинэ байр ашиглалтад орсонтой холбоотой байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 3 мэдээлэл, 4 мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

2. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байна. Акс Эрдэнэ ХХК-д мөнгөн хөрөнгөөс 13,092.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч шилэн дансанд 7,092.0 мянган төгрөг, Мөнх-Алтан зам групп ХХК-д мөнгөн хөрөнгөөс 9,561.2 мянган төгрөг шилжүүлсэн боловч шилэн дансанд мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээ хөрөнгийн хэмжээ 135,000.0 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 291,712.4 мянган төгрөг, Засгийн газрын оролцоо 156,712.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4-д үнэн зөв байх; гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийн алдааг үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв.

4.4.2.2 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 55,704.9 мянган төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.3 Төв аймгийн эрүүл мэндийн газраас эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон, Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн улсын бүртгэлийн гэрчилгээ дүрэмд эрхлэх үйл ажиллагаагаар бүртгэгдээгүй байгаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн нийтлэг шаардлагад 1.1-д "иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх", 1.2-т "хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан байх", 1.3-д "татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх", 2-т "Зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ", 2.1-д "хуульд заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх", 2.2-т "тухайн үйл ажиллагааг эрхлэх хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах", 2.3-д "хуулиар хориглосон, эсхүл хязгаарласан тохиолдолд зөвшөөрөлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй байх", 2.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг байнга эрхлэн явуулах", 2.5-д "зөвшөөрлийг эрх бүхий этгээдээс авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх", 2.6-д, 3 дугаар бүлгийн 3.2.2-т заасан хуульд заасан зарчмыг баримтлах, 2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд зөвшөөрөл олгох гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.4 Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг, эргэлтийн эмийн сан нэртэй эрхзүйн чадамжгүй, сан нь үйл ажиллагаа явуулахдаа байрны түрээсийн төлбөр төлдөггүй түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг төлж байгаа нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 20 дугаар зүйлд захирлын эрх үүрэгт 20.5-д "Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна", 21 дүгээр зүйлд "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр

хандив тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн татварын тухай, Төсвийн тухай хууль, Улсын бүртгэлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой бүртгэл, эмийн эргэлтийн сантай холбоотой нийт 8 зөвлөмж хүргүүлснээс 3 зөвлөмж 100 хувь хэрэгжүүлэн ажилласан, 5 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	52.0	1	52.0	100
Албан шаардлага	1	1,417.5	1	1,417.5	100
Зөвлөмж	2	60,813.4	1	1,313.5	50
Нийт дүн	4	62,282.9	3	2,783.0	87.5

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 62,282.9 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 52.0 төгрөгийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлага хэрэгжсэн, 2 зөвлөмж өгснөөс үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмж хэрэгжээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эмийн эргэлтийн сан нь байрны түрээсийн төлбөр төлдөггүй, хувь хүн иргэдэд олгосон цахим баримтыг байгууллагын регистрээр шивдэг, ашиглалтын зардал төлөхгүй байгаа асуудлыг авч үзэх. Нормативт зардлын гүйцэтгэлийг давтан хянах, худалдан авалт хийхдээ үнийн харьцуулалт хийдэг эсэх, гэрээний хэрэгжилтэд хяналт хийдэг эсэх, бичгээр харилцдаг эсэх, албан бичиг хэргийн хөтлөлтийг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,453.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 0.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 8,453.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

1. Нийгмийн даатгалын цахим тайлангийн системээр 2023 оны 12 дугаар сарын тайлан 0.5 төгрөгийн илүү төлсөн авлагатай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"; гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны 8,453.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байгаа нь нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө нотлогдох баримтаар гүйлгээ хийх, холбогдох хууль, дүрэм журам, стандартын шалгуурт нийцсэн байх, зүй зохистой иж бүрэн байх гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Нийгмийн даатгалын цахим тайлангийн системээр 2023 оны 12 дугаар сарын тайлан 0.5 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна	1	0.5			1	0.5							
Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны Цахим баримт 8,453.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	1	8,453.0					1	8,453.0					
Дүн	2	8,453.5			1	0.5	2	8,453.0					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 3 мэдээлэл, мэдээлээгүй 4 мэдээлэл байршуулсан байна.	1	0			1	0		
Акс Эрдэнэ ХХК-д мөнгөн хөрөнгөөс 13,092.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч шилэн дансанд 7,092.0 мянган төгрөг, Мөнх-Алтан зам групп ХХК-д мөнгөн хөрөнгөөс 9,561.2 мянган төгрөг шилжүүлсэн боловч шилэн дансанд мэдээлээгүй байна.	1	15,321.9			1	15,321.9		
Дүн	2	15,321.9			2	15,321.9		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засгийн газрын оролцоо 156,712.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	156,712.4					1	156,712.4
Үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 55,704.9 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.	1	55,704.9					1	55,704.9
Эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг	1						1	
Түрээсийн орлого ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг зориулалт бусаар зарцуулсан	1						1	
Дүн	4	212,417.3					4	212,417.3
Нийт дүн	6	227,739.2			2	15,321.9	4	227,739.2



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар АБ-14510516-ТӨА-2024/34/НА-СТ-ТШБ Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 15,321,900 /арван таван сая гурван зуун хорин нэгэн мянга есөн зуун/ төгрөг өссөн дүнгээр зөрүүтэй мэдээлсэн, хугацаа хоцорсон 3 мэдээлэл, мэдээлээгүй 4 мэдээлэл байршуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх";, 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ";, 6.4.4-д"таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэх;

²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040129

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг³ Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн дарга М.Түвшинтамир, нягтлан бодогч Б.Нарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

³Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

Монгол улс, Төв-аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И-мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn